

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2022 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: myangnboom@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1. Албан шаардлага	16
4.2 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБООУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНБООУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ХК	Хувьцаат компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № *2/119*

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 31.0 сая төгрөгийн үнэ бүхий хог тээврийн машин нь байгууллагын нэр дээр бүртгэлгүй, хувь хүний нэр дээр бүртгэгдсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг өгсөн байхад 2 жилийн хугацаанд зөрчлийг, бусад хангамжийн тайланг гаргахдаа эхний үлдэгдлийг хөрөнгө тус бүрээр гаргаагүй, бөөн дүнгээр гаргасан, Шилэн дансны тухай хуулийг бүрэн

• 005020537

хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайланд авлагыг бүрэн тусгаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Үнэн зөв байдал” зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,750,574.00</u>	<u>41,275,452.00</u>
33	АВЛАГА	7,816,397.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,397.00	00.00
335	Бусад авлага	7,798,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	208,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,590,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,934,177.00	41,275,452.00
351	Түүхий эд материал	1,578,675.00	1,581,800.00
35110	Тусгай зориулалттай материал	1,578,675.00	1,581,800.00
354	Хангамжийн материал	39,355,502.00	39,693,652.00
35410	Бичиг хэргийн материал	700,700.00	637,100.00
35420	Аж ахуйн материал	1,088,300.00	311,000.00
35440	Түлш, шатах тослох материал	585,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	36,981,502.00	38,745,552.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,731,090,646.94</u>	<u>1,795,440,129.69</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,731,090,646.94	1,795,440,129.69
392	Биет хөрөнгө	1,687,956,646.94	1,752,379,463.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,663,675,158.29	2,809,679,769.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,235,027,873.64	1,374,170,340.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,124,800.00	162,524,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-79,500,626.61	-90,956,253.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	247,922,183.80	226,088,393.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-170,535,980.90	-126,996,375.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,515,559.00	75,225,559.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,278,964.11	-50,177,279.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	74,808,721.00	129,126,487.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,624,999.89	-29,843,966.31
39217	Ном	21,878,670.00	21,878,670.00
393	Биет бус хөрөнгө	43,134,000.00	43,060,666.68
39301	Програм хангамж	1,175,000.00	1,175,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-735,000.00	-808,333.32
39303	Бусад биет бус хөрөнгө	42,694,000.00	42,694,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,779,841,220.94</u>	<u>1,836,715,581.69</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>300,000.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	300,000.00	00.00
413	Өглөг	300,000.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	300,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,779,541,220.94</u>	<u>1,836,715,581.69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,779,541,220.94	1,836,715,581.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,032,910.00	693,032,910.00
51101	Өмч: - төрийн	693,032,910.00	693,032,910.00
512	Хуримтлагдсан үр дүн	942,234,309.85	1,025,808,830.60
51210	Өмнөх үеийн үр дүн	942,234,309.85	968,634,469.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	57,174,360.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	144,274,001.09	117,873,841.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,779,841,220.94</u>	<u>1,836,715,581.69</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	575,107,399.80	842,375,323.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	144,749,824.80	279,738,447.00
120	Нийтлэг татварын бус орлого	144,749,824.80	279,738,447.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	144,749,824.80	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,513,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	143,236,824.80	00.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	0.00	231,592,647.00
120017	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	0.00	48,145,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	430,357,575.00	562,636,876.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,306,675.00	139,832,576.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	102,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,969,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,125,985.00	5,585,675.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,180,690.00	27,927,141.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	400,050,900.00	422,804,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	400,050,900.00	422,804,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	525,694,188.12	785,200,962.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,694,188.12	785,200,962.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,386,334.12	668,217,888.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,627,365.00	215,394,732.00
210101	Үндсэн цалин	222,627,365.00	215,394,732.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,682,749.00	28,499,658.00
210201	Тэтгэврийн даатгал	19,118,831.00	20,102,339.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,474.00	2,208,552.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,180.00	1,743,318.00
210204	Ажилгүйдлийн даатгал	407,346.00	396,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,103,918.00	4,048,649.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,987,053.00	44,498,953.00
210301	Гэрэл, цахилгаан	3,365,320.00	4,162,656.00
210302	Түлш, халаалт	40,621,733.00	40,336,297.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,934,582.00	91,962,376.00
210401	Бичиг хэрэг	4,041,100.00	2,800,710.00
210402	Тээвэр, шатахуун	21,386,693.00	30,059,191.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	675,525.00	583,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,408,860.00	5,970,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,537,140.00	51,477,255.00
210408	Бараа материал акалсны зардал	1,885,264.00	1,070,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,254,000.00	19,012,470.00
210602	Тавилга	2,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	8,254,000.00	19,012,470.00
2107	Томиллолт, зочны зардал	5,441,000.00	3,646,000.00
210702	Дотоод албан томиллолт	5,441,000.00	3,646,000.00

**Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,013,714.00	63,313,288.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,449,714.00	59,896,288.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,417,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,445,871.12	201,890,411.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-3,634,050.00	18,240,947.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,709,921.12	183,649,464.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,307,854.00	116,983,074.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	427,510.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	427,510.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37,057,854.00	116,555,564.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,960,036.00	25,694,868.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэлт	19,097,818.00	90,860,696.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	49,413,211.68	57,174,360.75
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	49,413,211.68	57,174,360.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	650,338,910.00	134,757,713.92	1,253,141,855.22	2,038,238,479.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	650,338,910.00	134,757,713.92	1,253,141,855.22	2,038,238,479.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-152,757,871.63	-152,757,871.63
C08	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	693,032,910.00	144,274,001.09	942,234,309.85	1,779,541,220.94
D01	2021 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	693,032,910.00	144,274,001.09	942,234,309.85	1,779,541,220.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	26,400,160.00	26,400,160.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,032,910.00	144,274,001.09	968,634,469.85	1,805,941,380.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-26,400,160.00	00.00	-26,400,160.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	57,174,360.75	57,174,360.75
D09	2021 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	693,032,910.00	117,873,841.09	1,025,808,830.60	1,836,715,581.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	431,870,575.00	562,636,876.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,513,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,513,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,513,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,513,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	430,357,575.00	562,636,876.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,306,675.00	139,832,576.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	102,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,969,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,125,985.00	5,585,675.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,180,690.00	27,927,141.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	400,050,900.00	422,804,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	400,050,900.00	422,804,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	419,930,575.00	546,230,576.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,930,575.00	546,230,576.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,622,721.00	428,278,502.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,627,069.00	215,394,735.00
210101	Үндсэн цалин	218,321,949.00	209,640,573.00
210104	Урамшуулал	13,675.00	68,575.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,291,445.00	5,685,587.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,701,442.00	28,481,258.00
210201	Тэтгэврийн даатгал	19,142,651.00	20,953,446.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,475.00	2,002,665.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,808,329.00	1,568,356.00
210204	Ажилгүйдлийн даатгал	402,220.00	354,575.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,096,767.00	3,602,216.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,572,053.00	43,912,753.00
210301	Гэрэл, цахилгаан	3,365,320.00	4,162,656.00
210302	Түлш, халаалт	41,206,733.00	39,750,097.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,787,475.00	34,982,645.00
210401	Бичиг хэрэг	3,483,300.00	3,323,310.00
210402	Тээвэр, шатахуун	20,632,650.00	25,881,265.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	711,525.00	583,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	4,794,450.00

**Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,405,000.00	20,030,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	165,000.00
210602	Тавилга	2,000,000.00	89,900.00
210604	Урсгал засвар	5,405,000.00	19,775,970.00
2107	Томилолт, зочны зардал	5,441,000.00	3,349,000.00
210702	Дотоод албан томилолт	5,441,000.00	3,349,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,975,257.00	56,344,014.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,411,257.00	52,780,014.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,113,425.00	25,783,227.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,213,425.00	25,783,227.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,307,854.00	117,952,074.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	1,396,510.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	1,396,510.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37,057,854.00	116,555,564.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,960,036.00	25,694,868.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэлт	19,097,818.00	90,860,696.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,940,000.00	16,406,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,940,000.00	16,406,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,940,000.00	16,406,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,940,000.00	16,406,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,940,000.00	16,406,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,940,000.00	-16,406,300.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	423,804,300.00	397,109,432.00	26,694,868.00	93.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,804,300.00	397,109,432.00	26,694,868.00	93.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,404,300.00	395,712,922.00	26,691,378.00	93.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,700,900.00	215,394,735.00	9,306,165.00	95.86
210101	Үндсэн цалин	218,182,800.00	209,640,573.00	8,542,227.00	96.08
210104	Урамшуулал	00.00	68,575.00	-68,575.00	#DIV/0!
210105	Гэрээт ажлын хөлс	6,518,100.00	5,685,587.00	832,513.00	87.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,074,700.00	28,481,258.00	3,593,442.00	88.80
210201	Тэтгэврийн даатгал	23,086,600.00	20,953,446.00	2,133,154.00	90.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,880,700.00	2,002,665.00	-121,965.00	106.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,164,000.00	1,568,356.00	595,644.00	72.47
210204	Ажилгүйдлийн даатгал	449,400.00	354,575.00	94,825.00	78.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,494,000.00	3,602,216.00	891,784.00	80.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,822,100.00	43,912,753.00	909,347.00	97.97
210301	Гэрэл, цахилгаан	4,346,000.00	4,162,656.00	183,344.00	95.78
210302	Түлш, халаалт	40,476,100.00	39,750,097.00	726,003.00	98.21
2104	Хангамж, бараа материалын зардал	39,322,300.00	34,982,645.00	4,339,655.00	88.96
210401	Бичиг хэрэг	3,128,200.00	3,323,310.00	-195,110.00	106.24
210402	Тээвэр, шатахуун	27,596,700.00	25,881,265.00	1,715,435.00	93.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,137,400.00	583,620.00	553,780.00	51.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,860,000.00	4,794,450.00	2,065,550.00	69.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	400,000.00	200,000.00	66.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,933,400.00	33,515,570.00	1,417,830.00	95.94
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,394,900.00	-2,394,900.00	#DIV/0!
210602	Тавилга	13,250,000.00	10,744,700.00	2,505,300.00	81.09
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	00.00	200,000.00	00.00
210604	Урсгал засвар	21,483,400.00	20,375,970.00	1,107,430.00	94.85
2107	Томилолт, зочны зардал	5,903,900.00	3,349,000.00	2,554,900.00	56.73
210702	Дотоод албан томилолт	5,903,900.00	3,349,000.00	2,554,900.00	56.73
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,508,400.00	7,372,134.00	136,266.00	98.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,944,400.00	3,808,134.00	136,266.00	96.55
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	00.00	100.00

**Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33138600.00	28704827.00	4,433,773.00	86.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,138,600.00	28,704,827.00	4,433,773.00	86.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1400000.00	1396510.00	3,490.00	99.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	1,396,510.00	3,490.00	99.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,396,510.00	3,490.00	99.75
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	423,804,300.00	397,109,432.00	26,694,868.00	93.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	422,804,300.00	397,109,432.00	25,694,868.00	93.92
132001	Орон нутгийн төсвөөс	422,804,300.00	397,109,432.00	25,694,868.00	93.92
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	00.00	1,000,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	00.00	1,000,000.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	21.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	05.00	05.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	00.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	21.00	00.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	05.00	05.00	00.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	09.00	09.00	00.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	07.00	07.00	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,971,880.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,971,880.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,971,880.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,971,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,971,880.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	139832576.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,832,576.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	102,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,969,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,585,675.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,927,141.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг ЗДТГ-ын дарга Э.Амгаланбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Уянга нар зурж, нярваар О.Батзолбоо ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Өндөр сумын ЗДТГ нь Засгийн газрын тогтоолоор захиргааны 4 багт хуваагдаж, улс төрийн албан тушаалтан 6, төрийн жинхэнэ албан хаагч 8, үйлчилгээний албан хаагч 6, гэрээт 1, нийт 21 орон тоогоор ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг 2019 онд батлан мөрдөж байсан ба 2021 онд аймгийн хэмжээнд мөрдөгдөх 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 525,694.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,885.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,519.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 785,200.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,778.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,244.6 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,836,715.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 56,874.4 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,750.6	41,275.5	(7,475.1)
Авлага	7,816.4	-	(7,816.4)
Бараа материал	40,934.2	41,275.5	341.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,731,090.6	1,795,440.1	64,349.5
Үндсэн хөрөнгө	3,279,794.1	3,468,392.7	188,598.6
Хуримтлагдсан элэгдэл	(1,548,703.4)	(1,672,952.5)	(124,249.1)
Нийт хөрөнгө	1,779,841.2	1,836,715.6	56,874.4
Өр төлбөр	300.0	-	(300.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,779,541.2	1,836,715.6	57,174.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,779,841.2	1,836,715.6	56,874.4

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд өвс тэжээл, мал худалдан борлуулсны орлогоор 7,590.0 мянга, шатахууны авлагаар 208.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаар 18.4 мянган төгрөгийн авлагатай байсныг тайлант онд барагдуулжээ.

Оны эхэнд 40,934.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 60,226.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 48,145.8 мянган төгрөгийн бараа материал авч, 106,959.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021.12.27-ний өдрийн А/50 дугаар тушаалаар хангамжийн материал дансанд бүртгэлтэй 9 нэр төрлийн 1,070.9 мянган төгрөгийн бараа материалыг актлан оны эцэст 41,275.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарчээ.

Оны эхэнд бүртгэлтэй 3,279,794.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж төсвийн хөрөнгөөр 16,406.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 231,592.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирснийг бүртгэсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.06.21-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор 1998 онд ашиглалтад орж элэгдлээ бүрэн нөхсөн 59,400.4 мянган төгрөгийн 2 ширхэг дизель моторыг “Чандмань Баянхонгор” ХК-д шилжүүлснээр оны эцэст 3,468,392.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 57,174.4 мянган төгрөгөөр нэмэгдэн 1,836,715.6 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх үеийн үр дүн данс 26400.2 мянган төгрөгөөр өөрчлөлт орсон нь хасагдсан мотортой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баян-Өндөр сумын ЗДТГ 2021 оны төсвийн төлөвлөлтийг 343,966.7 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг анх 423,804.3 мянган төгрөгөөр баталж, 2021 оны 7 дугаар сард төсвийг 17,788.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 423,804.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ нь батлагдсан 422,804.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 397,109.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан оны эцэст 25,694.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Баян-Өндөр сумын ЗДТГ өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөө өгсөн, тайлант онд өөрийн орлогоор спорт заалны орлого, тендерийн баримт бичгийн үнэ,

ухаалаг худгийн картын үнэ зэрэг орлого орсон ч өөрийн орлогоор тайлагнаагүй тул аудитаар зөвлөмж хүргүүлэв.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 145,832.6 мянган төгрөг төвлөрсний 80.5 хувь буюу 117,350.0 мянган төгрөг нь “Эрдэнэ монгол” ХХК-аас өгсөн хандив байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон санхүүжилтүүдийг зориулалтын дагуу зарцуулан оны эцэст 90,860.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баян-Өндөр сумын ЗДТГ-т “Эрдэнэ монгол” ХХК-аас 2021 оны 5 дугаар сард 15,000.0 мянга, 9 дүгээр сард 102,350.0 мянга, нийт 117,350.0 мянган төгрөгийг хандивлан нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлжээ.

Тус хандиваас 15,000.0 мянган төгрөгийг “Гео дата процессинг” ХХК-д шилжүүлж, сумын нутаг дэвсгэрт 10 худгийн хайгуул хийх гэрээг байгуулан ажлыг гүйцэтгэсэн байна.

Сумын эрүүл мэндийн төвд 14,000.0 мянган төгрөгөөр 1000 ширхэг ковидын тест, 13,000.0 мянган төгрөгөөр гематлогийн анализатор авч өгснийг эрүүл мэндийн төв нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд нийт 7 бүлэг зорилтын хүрээнд 50 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг даргаар 98.8 хувьтай дүгнүүлж, сумын ИТХ-ын хуралдаанд тайлагнасан байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн нь аудитаар тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, өөрийн орлогын гүйцэтгэлийг зөв тайлагнаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх “3.1.1. “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг”, 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн ... үнэн зөв байх” зарчмыг баримтална” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй тул “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгөв.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 619,408.5 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс 428,222.7 мянган төгрөгийг 35 мэдээллийг байршуулж, "Эрдэнэ монгол" ХХК-аас өгсөн 117,350.0 мянган төгрөгийн хандив, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 59,111.5 мянган төгрөгийн 6 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 9,498.7 мянган төгрөгийн 13 тушаалыг байршуулаагүй зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Бичиг хэргийн зардалд батлагдсан 3,128.2 мянган төгрөгийг 195.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах"
2. Тогтмол зардалд анх 46,999.3 мянган төгрөгөөр баталсныг тодотголоор бууруулан 44,822.1 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 97.9 хувь буюу 43,912.8 мянган төгрөгийг зарцуулан тогтоолын 1.8 дахь "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгснөөс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил давтагдсан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан хог тээврийн автомашин нь Монгол улсад орж ирсэн гаалийн бичигтэй боловч сумын ЗДТГ-ын эзэмшилд бүртгэгдээгүй, Ганбаяр гэсэн иргэний нэр дээр бүртгэлтэй" зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлагыг өгсөн ба Баян-Өндөр сумын Засаг даргын 2020.12.28-ы өдрийн 119 тоот албан бичгээр Өвөрхангай аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан ба тус асуудлыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2021.02.05-ны өдрийн 1/31 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн, асуудал шийдвэрлэгдээгүй, зөрчил арилаагүй байгааг тул цаашид албан шаардлагыг биелүүлж ажиллах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 173,019.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс 128,936.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 44,082.4 мянган төгрөгийн 5 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

4.1. Албан шаардлага

1. Баян-Өндөр сумын биет болон биет бус өв, байгалийн үзэсгэлэнт газрын тухай 36 минутын баримтат кино хийлгэх 2,535.0 мянган төгрөгийн ажлын гэрээг Улаанбаатар хотын "Титанс Пикчерс" ХХК-тай сумын Засаг дарга 2021.10.22-ний өдөр байгуулж, хөрөнгө зарцуулах А/175 дугаар захирамжийг 2021.12.17-ний өдөр гаргасан байна.

"Титанс Пикчерс" ХХК-аас авах хоолны тооцоог суутган тооцож, 2021.12.22-ний өдөр тус аж ахуйн нэгжид 2,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд ...бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагын зүйлсийг заавал бүртгэнэ", сумын Засаг дарга, "Титанс Пикчерс" ХХК-тай байгуулсан гэрээний 2.2-т "Гэрээт ажлын гүйцэтгэл бүрэн дуусаж, 2022 онд баримтат нэвтрүүлэг телевизээр цацагдсаны дараа тус орон нутагт хүлээлгэн өгнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баян-Өндөр сумын Засаг дарга, "Титанс Пикчерс" ХХК-тай байгуулсан гэрээний 2.2-т "Гэрээт ажлын гүйцэтгэл бүрэн дуусаж, 2022 онд баримтат нэвтрүүлэг телевизээр цацагдсаны дараа тус орон нутагт хүлээлгэн өгнө" гэсэн заалтын дагуу баримтат нэвтрүүлгийг 2022.09.30-ний дотор бүрэн бэлтгүүлэн хүлээн авах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад "Эрдэнэ монгол" ХХК-аас өгсөн 117,350.0 мянган төгрөгийн хандив, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 59,111.5 мянган төгрөгийн 6 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 3,175.1 мянган төгрөгийн 6 тушаалыг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 31,000.0 мянган төгрөгийн хог тээврийн машины бичиг баримтын зөрчлийг арилган, ЗДТГ-ын нэр дээр шилжүүлэх албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Хууль хяналтын байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэн, хөрөнгийг сумын ЗДТГ-ын нэр дээр шилжүүлэх.

2. Зардлын холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Баян-Өндөр сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн хуралдааны 02/13 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр спорт заалны орлого, тендерийн баримт бичгийн үнэ, ухаалаг худгийн картын үнэ зэрэг орлого орсон ч өөрийн орлогоор тайлагнаагүй нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Өөрийн орлогыг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх.

3. Зардлын холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Бичиг хэргийн зардалд батлагдсан 3,128.2 мянган төгрөгийг 195.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, тогтмол зардалд анх 46,999.3 мянган төгрөгөөр баталсныг тодотголоор бууруулан 44,822.1 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 97.9 хувь буюу 43,912.8 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах.

4. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Байгууллагын нярав О.Батзолбоо бусад хангамжийн тайлангийн эхний үлдэгдлийг хөрөнгө тус бүрээр гаргаагүй, бөөн дүнгээр гаргасан байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг хөрөнгийн нэр төрлөөр бэлтгэж, тайланг хянаж баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгаж байх.

5. Зардлын холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад 5,573.9 мянган төгрөгийн 13 гүйлгээний е баримт байхгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж: Цаашид аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс худалдан авалт хийхдээ дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлүүлж авах болон E-баримт.mn сайтаар өөрийн байгууллагын нэр регистрээр шивүүлж, худалдан авалтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/мянган төгрөгөөр/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Өндөр сумын ЗДТГ	7	173,019.0	0	0.00	0	0	2	128,936.6	5	44,082.4

---oOo---